


**ТӨРИЙН АЛБАТАЙ ХОЛБООТОЙ МАРГААНЫ ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ**

**PROBLEMS IN THE IMPLEMENTATION OF COURT DECISIONS IN
DISPUTES RELATED TO PUBLIC SERVANTS**



Э.Чимэдлхам

*Эрх зүй нийгмийн ухааны сургуулийн нийтийн эрх зүйн
тэнхимийн багш, докторант, цагдаагийн ахмад*

Хураангуй: Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдэж буй хэрэг маргааны нэлээд өндөр хувийг төрийн албаны маргаан эзэлж байгаа бөгөөд энэ төрлийн шийдвэр биелэгдэхгүй байгаа гол шалтгаан нь шүүхийн шийдвэр биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх бодит механизм байхгүй байгаатай холбоотой байж болно.

Түлхүүр үг: Төрийн алба, төрийн албан хаагч, захиргааны хэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэл,

Abstract: Civil service disputes account for a very high percentage of cases resolved by administrative courts, and the main reason why this type of decision is not implemented may be due to the lack of a real mechanism to hold officials accountable for not complying with the court's decision.

Keywords: Civil service, civil servant, administrative court, execution of decisions

Иргэн, хуулийн этгээдээс захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр хууль зөрчсөн гэж үзэн гаргасан нэхэмжлэлийг хянан шийдвэрлэж, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилготойгоор захиргааны хэргийн шүүх байгуулагдаад 19 жилийн нүүрийг үзээд байна.

Захиргааны хэрэг - нийтийн эрх зүйн маргаан, иргэн ба захиргааны хоорондын захирах, захирагдах харилцаанаас үүссэн маргаан, захиргааны

актын улмаас иргэн ба захиргааны хооронд үүссэн маргааныг нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийн шүүх хүлээн авч үүсгэсэн хэрэг юм.

Захиргааны хэрэг нь дараах онцлог шинжтэй:

- Хэргийн нэг талд заавал захиргааны байгууллага албан тушаалтан оролцоно
- Захиргаа ба иргэний захирах, захирагдах харилцаанаас үүснэ
- Захирах, захирагдах харилцааны явцад иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн байна¹.

Шүүхийн шийдвэр гэж шүүхээс хэрэг, маргааныг хянан хэлэлцээд гаргасан шийдэл. Шүүх шийдвэрээ Монгол Улсын нэрийн өмнөөс гаргана².

“Шүүхийн шийдвэр нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч эрх бүхий төрийн байгууллагаас гаргадаг, эрх зүйн харилцааг тодорхойлох, түүнийг зохицуулсан хэм хэмжээг хэрэглэх хэлбэрээр тухайн хэрэг маргаанд хамааралтай этгээдэд хуулиар тодорхойлогдсон төрийн хүсэл зоригийг илэрхийлдэг акт” гэж тодорхойлжээ³.

Захиргааны хэргийн шүүхийн гол зорилго бол захиргааны байгууллага албан тушаалтны хууль бус үйл ажиллагаанаас зөрчигдсөн хүний эрхийг сэргээн тогтоож, эдлүүлэх үүргээр илэрхийлэгддэг бол шийдвэр гүйцэтгэл нь энэ зорилгыг хангахад оршдог⁴.

Захиргааны хэргийн шүүх нь эрх тэгш бус субъектүүдийн хоорондын хууль ёсны ашиг сонирхлыг тэнцвэржүүлж, шийдвэрээрээ дамжуулан иргэн хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, нийтийн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр үйл ажиллагаанаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, хүний эрхийг хангах гол институт юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллага, албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэр хамаарах бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын эрх зүйн байдал зэргийг тогтоосон байна.

¹П.Одгэрэл “Захиргааны эрх зүйн ерөнхий анги” УБ, 2016 он

²С.Нарангэрэл “Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг” УБ, 2021 он, 159 тал

³Улсын дээд шүүхийн тогтоол, 2006.04.24, №21

⁴Б.Чимид, Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн, УБ, 2004 он, 42 дахь тал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гэх төрлүүдтэй байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гэдэг нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хүсэл гаргасны дараа гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан авах арга хэмжээний цогц юм. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хамгийн чухал зүйл бол нэхэмжлэгч, хариуцагчийн эрхийг хамгаалах замаар гүйцэтгэх ажиллагааны үр нөлөөг тэнцвэржүүлэх явдал юм.¹

Манай улсад 2015 оны 06 дугаар сарын 19-ны өдөр Захиргааны ерөнхий хууль шинээр батлагдсан. Үүнтэй холбоотойгоор захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль шинэчлэн батлагдсан бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохицуулсан нэмэлт өөрчлөлт орсон.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үргэлжлэл, төгсгөлийн шат нь бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зорилго нь шүүхээс гаргасан шийдвэрийг албадан биелүүлж, бусдын хуулиар хамгаалагдсан эрх ашгийг бодит байдалд сэргээхэд оршдог².

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлд³ Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах дараах үндэслэлийг зааж өгсөн байна.

6.3.Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дараах шийдвэрийг үндэслэн явуулна:

6.3.1.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12.1-д⁴ заасан захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр;

¹ Европын банк, ШШГЕГ, “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа” УБ, 2016 он

² А.Дугармаа “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онол практикийн асуудал” илтгэл

³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, “Төрийн мэдээлэл” 2017он, №24

⁴ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12.1.Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр дараахь хэлбэртэй байна:

12.1.1.анхан шатны шүүхийн шийдвэр;

12.1.2.магадлал;

12.1.3.тогтоол;

12.1.4.шүүгчийн захирамж;

12.1.5.шийтгэвэр.

6.3.2.захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай хуулийн хүчин төгөлдөр болсон шүүгчийн захирамж;

6.3.3.хялбаршуулсан журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол;

6.3.4.шүүхийн зардал тогтоосон шүүгчийн захирамж.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх агуулгаар нь ангилан авч үзвэл төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах, захиргааны зохих акт гаргуулахыг даалгасан шийдвэрийг гүйцэтгэх, тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх болон гүйцэтгэхгүй байхыг даалгасан шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа гэнэ¹.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дараах зармыг баримтална. Үүнд:

- Хууль дээдлэх;
- Хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, сахих;
- Шүүхийн шийдвэр заавал биелэгдэх;
- Шуурхай байх;
- Энэрэнгүй байх⁶

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дараах 5 үе шатад² хуваан авч үзье.

Нэгдүгээр үе шат: Хуулийн хүчин төгөлдөр болсон Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, захиргааны шийтгэвэр, мөн эвлэрлийн гэрээг баталгаажуулсан захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн захирамж, тэдгээрийн үндсэн дээр олгосон гүйцэтгэх хуудсыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд ирүүлсэн байна. Энэ нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл болно.

Хоёрдугаар үе шат: Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх. Гүйцэтгэх баримт бичгийн агуулга, түүнд тавигдах шаардлага хангагдаж байвал Ахлах шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тогтоол үйлдэж харьяа тойргийн шийдвэр гүйцэтгэгчид хуваарилна.

¹А.Эрдэнэцогт, Захиргааны процессын эрх зүй, УБ, 2006, 300 дахь тал

² “Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн” гарын авлага 2004 он

Гуравдугаар үе шат: Хугацаатай мэдэгдэл хүргүүлэх Мэдэгдэл нь төлбөр төлөгч, төлбөр авагч, холбогдох бусад этгээдийг мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлэх зорилгыг хангахаас гадна төлбөр төлөхийг шаардах, тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх, эсхүл тодорхой үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгах тухай хугацаатай үүрэг оногдуулсныг хүргүүлэх зорилгыг агуулсан хоёр хэлбэртэй байдаг.

Дөрөвдүгээр үе шат: Албадан биелүүлэх Шийдвэр гүйцэтгэгч шийдвэрийг сайн дураар биелүүлэх хугацаа тогтоон өгч болох бөгөөд тогтоосон хугацаанд сайн дураар биелүүлээгүй бол албадан гүйцэтгэнэ.

Тавдугаар үе шат: Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох Шийдвэр гүйцэтгэгч дараах үндэслэлээр буюу төлбөр авагч төлбөр авахаас татгалзсан, төлбөр төлөгч төлбөрөө бүрэн төлсөн, талууд эвлэрсэн, эрх залгамжлах тохиолдолд эрх, үүрэг нь гуравдагч этгээдэд шилжээгүй тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болсонд тооцож, шийдвэр гарган гүйцэтгэх баримт бичгийг хаана.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн 2173 хэргийн 480 хэрэг буюу 22.1 хувийг газрын маргаан, 425 буюу 19.6 хувийг төрийн хяналт шалгалтын маргаан, 242 хэрэг буюу 11.1 хувийг төрийн албаны маргаан, 309 буюу 14.2 хувийг бусад төрлийн маргаан, 198 буюу 9.1 хувийг шинэ төрлийн маргаан, 100 буюу 4.6 хувийг ашигт малтмалын маргаан, 66 хэрэг буюу 3.0 хувийг татварын маргаан, 67 буюу 3.1 хувийг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авахтай холбоотой маргаан, 52 хэрэг буюу 2.4 хувийг эд хөрөнгийн эрхийн бүртгэлтэй холбоотой, 50 буюу 2.3 хувийг нийгмийн даатгалын маргаан, 21 буюу 1.0 хувийг барилгын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргаан, 12 буюу 0.6 хувийг сонгуулийн маргаан, 37 буюу 1.7 хувийг тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргаан, 27 буюу 1.2 хувийг хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой, 8 буюу 0.4 хувийг иргэний бүртгэлтэй холбоотой маргаан, 3 буюу 0.1 хувийг шударга өрсөлдөөнийг хянан зохицуулах, хэрэглэгчийн эрх ашигтай холбоотой маргаан тус тус эзэлж байна¹. Үүний дотроос захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн төрийн албаны 2020, 2021, 2022 оны маргааныг харьцуулан үзвэл нийт шийдвэрлэгдсэн хэрэг маргааны 10 дээш хувийг тогтмол эзэлж байгаа нь харагдаж байна.

¹Шүүхийн ерөнхий зөвлөлийн тайлан 2022 он

Он	Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн нийт хэрэг	Төрийн албаны маргаан	Нийт хэрэгт эзлэх хувь
2020	1524	199	13,1%
2021	1764	305	17,3%
2022	2173	242	11.1%

Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын баримт бичгийн мэдээнээс харахад 2018-2021 онд захиргааны хэргийн шүүхийн шийдвэр 42 хувьтай биелэгдсэн байна. Өөрөөр хэлбэл дээрх тоон үзүүлэлт нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл хангалтгүй байгааг харуулж байна. 2021 онд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд байгаа нийт 225 хэргийн хамгийн их буюу 55 /24%/ нь төрийн албан хаагчийг ажилд эрүүлэн тогтоох, ажилгүй байсан хугацааны цалинг олгохтой холбогдсон маргаан байна¹. Шийдвэр биелүүлэхгүй байгаа 145 албан тушаалтнаас 30 буюу 20 хувь нь Нийслэлийн засаг дарга байна.

Төрийн албан хаагчийн ажилгүй байсан хугацааны цалинг шүүхээс буруутай албан тушаалтны байгууллагаас олгохоор шийдвэрлэдэг ба жилд дунджаар 450,000,000-500,000,000 төгрөгийн хохирлыг төрд учруулдаг байна. Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн² холбогдох зүйлүүдэд байгууллагад учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаас гаргуулах зохицуулалтыг тусгасан ч хэрэгжилт хангалтгүй байна.

2017 оны “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-д Шийдвэр гүйцэтгэгч шүүхийн мэдэгдэлд заасан хугацаа, эсхүл нэмэлт хугацаа тогтоосон бол тухайн хугацаа дуусмагц шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй захиргааны байгууллага албан тушаалтны дээд шатны байгууллага, албан тушаалтны дээд шатны байгууллага, албан тушаалтан шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авахыг даалгасан мэдэгдэл хүргүүлнэ³ гэжээ.

Дүгнэлт

¹С.Амбасэлмаа “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь” илтгэл

²Захиргааны ерөнхий хуулийн 103.1 Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ.

³Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2012 он, 132.2 зүйл

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр бүрэн гүйцэт биелэгдэж байх нь эрх зүйн соёл, ухамсрын түвшин харилцан адилгүй олон нийтийн зүгээс Захиргааны хэргийн шүүхийг хүлээн зөвшөөрөхөд чухал ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрээс шууд хамааралтай байх онцлогтой.

Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдэж буй хэрэг маргааны нэлээд өндөр хувийг төрийн албаны маргаан эзэлж байна. Тухайлбал: 2020, 2021, 2022 онд Захиргааны хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн нийт хэргийн 10-аас дээш хувийг төрийн албатай холбоотой маргаан эзэлж байгаа бөгөөд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд байгаа /2021 он/ нийт хэргийн 20 гаруй хувь нь төрийн албан хаагчийг ажилд эргүүлэн тогтоох, ажилгүй байсан хугацааны цалинг олгохтой холбогдсон маргаан байна. Энэ төрлийн шийдвэр биелэгдэхгүй байгаа гол шалтгаан нь шүүхийн шийдвэр биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх бодит механизм байхгүй байгаатай холбоотой байж болно.

Захиргааны ерөнхий хуулийн холбогдох зүйлүүдэд байгууллагад учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаас гаргуулах зохицуулалтыг тусгасан ч хэрэгжилт хангалтгүй байна. Иймд тухайн гэм буруутай албан тушаалтан албан тушаалаасаа чөлөөлөгдөх магадлалтай учир албан тушаалд нь бус хувь хүнд нь хандан заавал төлөхийг үүрэг болгон зохицуулах мөн шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй хоног тутамд торгууль оногдуулах эрх зүйн зохицуулалт оруулах нь төрийн албатай холбоотой дийлэнх маргааны шийдвэр гүйцэтгэлийг хангахад чухал ач холбогдолтой юм.

---o0o---